



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот

Тарифт өөрчлөлт оруулах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны "Тариф шинэчлэн батлах тухай" 2023 оны 98 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол шуудан ХК-ийн давамгай байдалтай үйлчилгээний тариф", 1.Хотын доторх бичиг захидлын үйлчилгээний тариф, 2.Хот хоорондын бичиг захидлын үйлчилгээний тарифыг хавсралтаар өөрчлөн баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 98 дугаар тогтоолын хавсралтын 1.хотын доторх бичиг захидлын үйлчилгээний тариф, 2.хот хоорондын бичиг захидлын үйлчилгээний тариф, 2013 оны 55 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Батлагдсан тарифын хязгаарт багтаан үйлчилгээний үнэ тарифыг тогтоох, үйлчилж эхлэхээс өмнө хэрэглэгчдэд мэдээлэх, бэлтгэл ажлыг зохион байгуулж 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг Монгол Шуудан ХК-д зөвшөөрсүгэй.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИЦҮҮД

Б.АНХБААТАР


Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР



МОНГОЛ ШУУДАН ХК-ИЙН
ДАВАМГАЙ БАЙДАЛТАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ
/ДЭЭД/

1. Хотын доторх бичиг захидлын үйлчилгээ /НӨАТ-гүй/:

Төрөл/жингийн шатлал			Тариф (Төгрөгөөр)
Аймаг, хотын дотор	Энгийн захиа	Ширхэг /100 гр хүртэл/	1,100
		Дараагийн бүрэн ба бүрэн бус 100 гр тутамд	500
	Бүртгэгдсэн захидал	Ширхэг /100 гр хүртэл/	4,500
		Дараагийн бүрэн ба бүрэн бус 100 гр тутамд	500
	Буухиа захидал	Ширхэг /100 гр хүртэл/	6,000
		Дараагийн бүрэн ба бүрэн бус 100 гр тутамд	1,000

2. Хот хоорондын бичиг захидлын үйлчилгээ /НӨАТ-гүй/:

Төрөл/жингийн шатлал			Тариф (Төгрөгөөр)
Аймаг, хот хооронд	Энгийн захиа	Ширхэг /100 гр хүртэл/	1,500
		Дараагийн бүрэн ба бүрэн бус 100 гр тутамд	500
	Бүртгэгдсэн захидал	Ширхэг /100 гр хүртэл/	6,000
		Дараагийн бүрэн ба бүрэн бус 100 гр тутамд	500
	Буухиа захидал	Ширхэг /100 гр хүртэл/	10,000
		Дараагийн бүрэн ба бүрэн бус 100 гр тутамд	2,000